

# ҮР БОЛОН НОГООН МӨЧРИЙН ҮНИЙН САНАЛ АВАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ БА УДИРДАМЖ

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү ажлын даалгавар нь төслийн 5 га талбайд байгуулах мод үржүүлгийн талбайд мод, бут сөөгийн үр, ногоон мөчир болон харандаан мөчир нийлүүлэхтэй холбоотой үнийн санал авах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Мод үржүүлгийн талбай нь төслийн тогтвортой хэрэгжилтийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дотоодын эх үүсвэрт тулгуурлан суулгац үйлдвэрлэх, цаашдын ойжуулалтын ажлыг тасралтгүй хангах зорилготой.

## 2. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

### Мод үржүүлгийн газрын байршил ба талбай

Мод үржүүлгийн газар нь Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хороо, Гандангийн аманд байрлах бөгөөд дараах үндсэн үзүүлэлттэй байна:

- Нийт талбай: 500-1,000 м<sup>2</sup>
- Бүтэц:  
6 × 20 м хэмжээтэй 2 ширхэг хүлэмж  
Ил талбайн тарималжуулалтын хэсэг

### Газар бэлтгэх ажил

Тариалалтын өмнө дараах бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ:

- Талбай цэвэрлэх, тэгшлэх
- Тарималжуулах талбайн зохион байгуулалт хийх
- Хүлэмж болон ил талбайн тариалалтын хэсгийг бэлтгэх

### Тариалалт хийх

Навчит болон шилмүүст мод, бут сөөгийг зориулалтын дагуу хүлэмж болон ил талбайд төрөл тус бүрээр ангилан тарималжуулна.

## 3. МОД, БУТ СӨӨГИЙН ЗҮЙЛ БОЛОН СУУЛГАЦЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Техникийн үнэлгээний багийн зөвлөмжийн дагуу нийт 11 төрлийн мод, бут сөөгийг үр, ногоон мөчир болон харандаан мөчрөөр үржүүлнэ.

2028 оны тарилтын улиралд нийт 38,600 ширхэг суулгац бэлтгэн гаргахаар төлөвлөж байна.

№	Модны зүйл	Нийлүүлэх төрөл	Хэмжих нэгж	1м <sup>2</sup> -аас гарах суулгацны тоо	Тариалах талбай, м <sup>2</sup>	Гарах суулгацны тоо, ш	Тайлбар
1	Голт бор	Үр	кг	60	20	1,200	Хавар, зун
2	Үхрийн нүд	Ногоон мөчир	ширхэг	60	20	1,200	7 сард
3	Бүйлс	Үр	кг	60	20	1,200	2026 оны намар тарих
4	Шар хуайс	Үр	кг	100	100	10,000	2026 оны хавар, зун
5	Хайлаас	Үр	кг	100	100	10,000	2026 оны хавар, зун
6	Гүйлс	Үр	кг	80	20	1,600	2026 оны намар тарих
7	Улаалзгана	Ногоон мөчир	ширхэг	60	20	1,200	7 сард
8	Тэсмэг	Ногоон мөчир	ширхэг	50	20	1,000	7 сард
9	Улиас	Харандаан мөчир	ширхэг	50	100	5,000	6 сарын 05-ны дотор
10	Тэхийн шээг	Ногоон мөчир	ширхэг	60	20	1,200	7 сард
11	Улиангар	Харандаан тайрдас	ширхэг	50	100	5,000	6 сарын 05-ны дотор
<b>Дүн:</b>						<b>38,600</b>	

## 4. НИЙЛҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Чанарын шаардлага

Нийлүүлж буй үр болон мөчир нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тухайн зүйлийн стандарт, техникийн шаардлагад нийцсэн байх
- Харандаан мөчир нь эрүүл, механик гэмтэлгүй, өвчин хортонгүй байх
- Үрийн соёололтын хувь 85%-иас доошгүй байх
- Ногоон болон харандаан мөчрийг зохих хугацаанд тайрч, стандартын дагуу хадгалж, тээвэрлэх

### Хүргэлтийн шаардлага

- Нийлүүлэлтийг хүснэгтийн “Тайлбар” баганад заасан хугацаанд гүйцэтгэнэ.
- 7 дугаар сард нийлүүлэх материалыг тухайн сарын эхний долоо хоногт хүргэнэ.
- 6 дугаар сарын 05-ны дотор нийлүүлэх материалыг заасан хугацаанаас өмнө хүргүүлсэн байна.
- 2026 оны намрын тариалалтын материалуудыг тухайн улиралтай уялдуулан нийлүүлнэ.
- Нийлүүлэлтийг төслийн байршилд гүйцэтгэх бөгөөд тээврийн зардлыг үнийн саналд тусгасан байна.

## **Баримт бичгийн шаардлага**

- Тариалан, бэлтгэлийн аргачлалыг тайлбарласан техникийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Ногоон мөчир, харандааны хувьд тайрсан огноо, хадгалалтын аргыг бичгээр гаргана

## **5. ҮНИЙН САНАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Нийлүүлэгч нь дараах мэдээллийг багтаасан үнийн саналыг ирүүлнэ. Үүнд:

- Зүйл тус бүрийн нэгж үнэ
- Нийт нийлүүлэх тоо хэмжээ болон нийт үнийн дүн
- Хүргэлтийн нөхцөл, тариалалтын ажлын төлөвлөгөө, хугацаа
- Тариалалтын ажлын гүйцэтгэлийн хөлс